

САНАЛ АСУУЛГА

1.Хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

3.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

4.Аймаг, сумдын Засаг дарга нараас иргэдэд үзүүлж буй үйлчилгээ

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

Төрөөс нэн түрүүнд ямар үйлчилгээ авахыг хүсч байна вэ?

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭГ ТООЦСОН ДҮН

2011.03.25

Улиастай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2010 оны 6, 8 дугаар сард бүх сумдын төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгүүдийн удирдамжид тусган, Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын 5.8 дахь заалтыг хэрэгжүүлж, Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний үнэлгээ гэсэн үзүүлэлтээр сумдын насанд хүрсэн иргэдийн 5 хүртэл хувийг хамруулж, санал асуулга явуулсан. Үүний дүнг үндэслэн хэрэглэгчийн үнэлгээг гаргаж байна. Санал асуулгад нийт 2950 хүн оролцож, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 4.68, Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмж 4.85, нийт үнэлгээ 4.76 буюу 95,3 хувийн дүнтэй байна.

Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай, Булган, Увс аймгуудад болон өөрийн аймгийн сумдын нутагт отор хийж яваа малчдыг эргэх ажлыг томилогдсон ажлын хэсэг 2-3 удаа зохион байгуулж малчдад хүн, мал, эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, санал хүсэлтийг сонсож, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд хариуцуулж үүрэг даалгавар өгч хэрэгжүүлж байна. Мөн Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалт семинарын үеэр авсан төрөл бүрийн судалгааны дүн санал дүгнэлтийг төрийн байгууллагуудын бодлого чиглэлд тусгаж байна.

Төрөөс нэн түрүүнд ямар үйлчилгээ авахыг хүсч байна вэ? гэсэн асуултад иргэд доорх хүсэлтүүдийг тавьж байна.

- Хөдөө, орон нутагт мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, тэдний нийгмийн баталгааг сайжруулах

- Хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа төрийн албан хаагчид болон залуу гэр бүлийг орон сууцны квотод багтаах,

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөнгөлөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах

- Малчдыг банкны зээлийн өрийн дарамтаас чөлөөлөх, хүүг хөнгөлөх талаар дэмжлэг үзүүлэх

- Ажлын байр нэмэгдүүлэх

- Төрөөс олгож байгаа эрүүл мэнд, боловсрол, хууль, шүүх, бүх төрлийн үйлчилгээг ялгаварлалгүй, жигд хүртээмжтэй үзүүлэх

- Оюутан, сурагчдын сургалтын төлбөрийг төрөөс хариуцан төлөх, хөнгөлөлт үзүүлэх

- Төрийн албан хаагчдад 5 жилд нэг удаа мөнгөн тэтгэмж өгдөг тогтолцоог бүрдүүлэх

- Орон нутагт өвөлжилт хүндэрч, зуд болсноос олон өрх малгүй болж, ажилгүйдэл, ядуурал ихсэж байгаа тул цаашид малжуулах бодлого баримтлах хэрэгтэй байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР